



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

САЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2024/68/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: 7034-2580

Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 7034-2716

Цахим хаяг: enkhsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном

Утас: 70242495

Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл  
.....
- 4.2 Материаллаг байдал  
.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал  
.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 316  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

САЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
С.ЛУВСАНЦООДОЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхан сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сайхан сумын ЗДТГ-ын -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сумын өвс тэжээлийн нөөц нь нэмэлт санхүүжилтийн дансны 25,789,000.00, ЖДҮД сангийн 53,289,159.00 нийт 79,078,159.00 төгрөгийн эх үүсвэр байна. Үүнээс 47,400,634 төгрөг нь дансны үлдэгдлээр, 16,687,954 мянган төгрөг нь авлагаар, бусад хангамжийн материалын дансанд 2283 боодол буюу 21,999,000 төгрөгийн өвсний нөөцтэй байна.

Авлагын үлдэгдлээс 8,178,400 төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, өвс тэжээл борлуулсны орлогоос 8,509,554 төгрөгийг дансанд төвлөрүүлээгүй,

ЗДТГ-ын нягтлан бодогч нь тушаал, шийдвэргүй төсөвт баталгаажуулаагүй орон тооны ажлыг хавсран гүйцэтгэж 40 хувийн нэмэгдэл болох 3,445,960 төгрөгийн цалин авсан,

Энэ нь Төсвийн тухай хууль 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" НББ-ийн тухай хуулийн 13 дугаар 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", "20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж,

000000708

үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтууд, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллагын тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

#### **Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Сумын өвс тэжээлийн нөөцийн авлага 21,353.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлан онд 4,167.4 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сайхан сумын ЗДТГ нь 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 5 зорилт, 27 арга хэмжээний хэрэгжилт 91.0 хувиар дүгнэсэн, хөтөлбөр арга хэмжээнд зориулан 760,285.0 мянган төгрөгийг төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 99.9 хувийг зарцуулсан байна.

Сайхан сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>59,098,131.40</u></b>	<b><u>101,911,360.55</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	16,152,680.20	46,217,859.35
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	210,298.15
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	16,152,680.20	46,007,561.20
3351	Байгууллагаас авах авлага	10,814,682.20	24,653,995.20
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,337,998.00	21,353,566.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	28,189,451.20	33,694,501.20
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	937,243.20	937,243.20
35110	Тусгай зориулалттай материал	937,243.20	937,243.20
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	23,192,208.00	28,697,258.00
35410	Бичиг хэргийн материал	147,000.00	836,000.00
35420	Аж ахуйн материал	12,716,483.00	17,052,533.00
35430	Сэлбэг хэрэгсэл	10,328,725.00	10,808,725.00
35600	Мал амьтад	4,060,000.00	4,060,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	14,756,000.00	21,999,000.00
36300	Тэжээлийн нөөц	14,756,000.00	21,999,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,184,413,901.13</u></b>	<b><u>1,859,933,278.98</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,184,413,901.13	1,859,933,278.98
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,182,692,651.16	1,858,422,029.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,109,403,865.03	1,764,922,665.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(267,804,587.08)	(294,147,165.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	168,884,800.00	180,751,144.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(120,378,644.30)	(94,415,711.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	137,360,053.00	163,808,653.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,444,062.70)	(59,435,429.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,634,069.64	48,634,069.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,333,037.45)	(17,641,334.48)
39209	Зам, гүүрийн байгууламж	133,304,200.00	133,304,200.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(47,544,283.97)	(51,252,253.73)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	20,176,300.00	20,176,300.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	74,262,638.33	74,262,638.33
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,828,659.34)	(10,545,747.24)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,721,249.97	1,511,249.97
39301	Програм хангамж	2,100,000.00	2,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(378,750.03)	(588,750.03)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,243,512,032.53</u></b>	<b><u>1,961,844,639.53</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>4,247,380.98</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	4,247,380.98
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	4,247,380.98
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	4,167,380.98
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	80,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	80,000.00

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,243,512,032.53</b>	<b>1,957,597,258.55</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,243,512,032.53	1,957,597,258.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	612,751,072.17	612,751,072.17
51101	Өмч: - төрийн	612,751,072.17	612,751,072.17
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	145,642,621.36	859,727,847.38
51210	Өмнөх үеийн үр дүн	145,642,621.36	145,642,621.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	714,085,226.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	485,118,339.00	485,118,339.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,243,512,032.53</b>	<b>1,961,844,639.53</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>592,752,538.20</b>	<b>2,282,170,981.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>39,648,000.00</b>	<b>708,670,159.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	39,648,000.00	708,670,159.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,648,000.00	708,670,159.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,484,515.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,348,000.00	701,185,644.00
120009	Бусад орлого		-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>553,104,538.20</b>	<b>1,573,500,822.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	57,449,338.20	879,362,630.00
131103	ЗГНХ,ЗДНХХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,500,000.00	861,907,205.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,998,528.00	17,175,425.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,950,810.20	280,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	495,655,200.00	694,138,192.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	495,655,200.00	694,138,192.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>537,018,593.62</b>	<b>1,568,085,754.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>537,018,593.62</b>	<b>1,568,085,754.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	474,153,406.98	1,551,399,409.52
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	240,392,375.35	434,227,057.34
210101	Үндсэн цалин	191,041,011.25	273,273,860.89
210102	Нэмэгдэл	35,320,998.00	101,137,082.75
210104	Урамшуулал	14,030,366.10	35,398,746.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	24,417,367.70
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,791,239.01	53,503,440.12
210201	Тэтгэврийн даатгал	20,542,819.42	36,143,217.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,387,739.38	4,360,680.47

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,910,191.32	3,466,544.54
210204	Ажилгүйдлийн даатгал	450,044.15	866,636.27
210205	Эрүүл мэндийн даатгал	4,500,444.74	8,666,361.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,919,299.00	50,969,880.99
210301	Гэрэл, цахилгаан	8,294,436.00	11,998,105.38
210302	Түлш, халаалт	34,624,863.00	38,971,775.61
210304	Байрны түрээс		-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	63,968,903.00	47,620,106.00
210401	Бичиг хэрэг	6,655,600.00	6,299,800.00
210402	Тээвэр, шатахуун	42,334,590.00	39,947,106.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	970,600.00	1,223,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,008,113.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,158,500.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	245,500.00	-
210502	Хоол, хүнс	3,913,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,948,550.00	29,162,960.00
210604	Урсгал засвар	1,948,550.00	29,162,960.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,768,000.00	10,250,800.00
210702	Дотоод албан томилолт	6,768,000.00	10,250,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	450,000.00	4,385,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	450,000.00	4,385,125.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	83,756,540.62	921,280,040.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,509,550.00	870,675,673.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,246,990.62	50,304,366.15
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	62,865,186.64	16,686,345.46
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,640,890.00	5,804,368.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,829,790.00	3,874,368.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,011,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	1,930,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	28,224,296.64	10,881,977.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,224,296.64	10,881,977.46
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>55,733,944.58</b>	<b>714,085,226.02</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	12,563,446.25	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,121,546.25	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,441,900.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(12,563,446.25)	-

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>577,103,410.20</b>	<b>1,620,020,951.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,300,000.00</b>	<b>7,484,515.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,300,000.00	7,484,515.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,300,000.00	7,484,515.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,300,000.00	7,484,515.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>575,803,410.20</b>	<b>1,612,536,436.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	80,148,210.20	918,398,244.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,500,000.00	861,907,205.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,998,528.00	17,175,425.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,649,682.20	39,315,614.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	495,655,200.00	694,138,192.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	495,655,200.00	694,138,192.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>528,329,010.20</b>	<b>1,593,572,351.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>528,329,010.20</b>	<b>1,593,572,351.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>454,649,141.36</b>	<b>1,552,232,010.54</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	240,544,957.64	429,187,457.79
210101	Үндсэн цалин	190,801,033.00	259,713,431.16
210102	Нэмэгдэл	35,320,998.00	113,486,398.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	366,000.00	-
210104	Урамшуулал	14,056,926.64	34,883,776.60
210105	Гэрээт ажлын хөлс	-	21,103,851.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,692,656.72	54,585,956.84
210201	Тэтгэврийн даатгал	20,470,799.42	37,225,737.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,387,739.38	4,360,679.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,910,191.32	3,466,543.87
210204	Ажилгүйдлийн даатгал	423,481.86	866,635.84

210205	Эрүүл мэндийн даатгал	4,500,444.74	8,666,360.09
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		
		42,919,299.00	50,781,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,294,436.00	11,809,224.39
210302	Түлш, халаалт	34,624,863.00	38,971,775.61
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		
		39,033,353.00	42,948,695.00
210401	Бичиг хэрэг	7,003,700.00	6,378,000.00
210402	Тээвэр, шатахуун	28,616,140.00	31,919,225.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,024,625.00	1,241,270.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	673,888.00	1,865,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,715,000.00	1,544,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		
		4,810,100.00	300,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	160,100.00	-
210502	Хоол, хүнс	4,150,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	300,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		
		23,006,675.00	27,203,910.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210602	Тавилга	536,000.00	550,000.00
210604	Урсгал засвар	22,470,675.00	26,653,910.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		
		6,768,000.00	10,250,800.00
210702	Дотоод албан томилолт	6,768,000.00	10,250,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		
		4,993,500.00	4,345,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,993,500.00	4,345,125.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		
		62,880,600.00	932,629,065.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,880,600.00	931,300,465.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,328,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>73,679,868.84</b>	<b>41,340,340.46</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		
		34,640,890.00	5,804,368.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,829,790.00	3,874,368.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,011,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	1,930,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		
		28,224,296.64	10,881,977.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,224,296.64	10,881,977.46
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
		10,814,682.20	24,653,995.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,814,682.20	24,653,995.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	48,774,400.00	26,448,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	48,774,400.00	26,448,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,774,400.00	26,448,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	48,774,400.00	26,448,600.00
223001	Бусад хөрөнгө	48,774,400.00	26,448,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(48,774,400.00)	(26,448,600.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,751,072.17	485,190,934.72	102,399,527.31	1,200,341,534.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,751,072.17	485,190,934.72	102,399,527.31	1,200,341,534.20
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	72,596.72	72,596.72
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	(72,596.72)	-	(72,596.72)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	43,170,498.33	43,170,498.33
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,751,072.17	485,118,338.00	145,642,622.36	1,243,512,032.53
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	612,751,072.17	485,118,338.00	145,642,622.36	1,243,512,032.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,751,072.17	485,118,338.00	145,642,622.36	1,243,512,032.53
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	714,085,226.02	714,085,226.02
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,751,072.17	485,118,338.00	859,727,848.38	1,957,597,258.55

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	706,285,000.00	690,740,729.54
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	706,285,000.00	690,740,729.54
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	700,360,600.00	684,936,361.54
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	443,311,900.00	429,187,457.79
210101	Үндсэн цалин	271,463,700.00	258,580,633.73
210102	Нэмэгдэл	126,922,800.00	112,819,196.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	24,652,700.00	34,883,776.60
210105	Гэрээт ажлын хөлс	20,272,700.00	22,903,851.21
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,413,900.00	54,585,956.84
210201	Тэтгэврийн даатгал	37,681,600.00	37,225,737.60
210202	Тэтгэмжийн даатгал	4,433,100.00	4,360,679.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,546,500.00	3,466,543.87
210204	Ажилгүйдлийн даатгал	886,600.00	866,635.84
210205	Эрүүл мэндийн даатгал	8,866,100.00	8,666,360.09
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	50,781,000.00	50,781,000.00
210301	Гэрэл, цахилгаан	11,800,000.00	11,809,224.39
210302	Түлш, халаалт	38,981,000.00	38,971,775.61
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,814,200.00	34,664,270.00
210401	Бичиг хэрэг	5,939,000.00	5,939,000.00
210402	Тээвэр, шатахуун	24,073,800.00	24,073,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,340,000.00	1,241,270.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,961,400.00	1,865,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,544,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	53,698,600.00	53,652,510.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,450,000.00	3,450,000.00
210602	Тавилга	23,548,600.00	23,548,600.00
210604	Урсгал засвар	26,700,000.00	26,653,910.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	9,239,800.00	9,170,800.00
210702	Дотоод албан томилолт	9,239,800.00	9,170,800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,295,000.00	1,275,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,295,000.00	1,275,125.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	51,806,200.00	51,619,241.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,460,800.00	50,290,641.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,345,400.00	1,328,600.00

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,924,400.00	5,804,368.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,924,400.00	5,804,368.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,874,400.00	3,874,368.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.00	1,930,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	706,285,000.00	690,740,729.54
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	699,485,400.00	683,256,214.54
132001	Орон нутгийн төсвөөс	699,485,400.00	683,256,214.54
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	6,799,600.00	7,484,515.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,799,600.00	7,484,515.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-
610001	Төсвийн байгууллага		
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	-	-
620001	Удирдах ажилтан	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-
620003	Үйлчлэх ажилтан	-	-
620004	Гэрээт ажилтан		

## 2.5 Аудит хийсэн төсвийн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>893,744,249.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>893,744,249.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	893,744,249.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	8,284,425.00
210401	Бичиг хэрэг	-	439,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	7,845,425.00
2105	<b>Нормативт зардал</b>	-	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	300,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	-	1,080,000.00
210702	Дотоод албан томилолт	-	1,080,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	3,070,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,070,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	881,009,824.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	881,009,824.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	918,398,244.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	918,398,244.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	861,907,205.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,175,425.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	39,315,614.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 78,414.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 26,104.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 12,131.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 8,178.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 32,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

➤ ЗДТГ-ын нягтлан бодогч М.Мөнхтөр нь тушаал, шийдвэргүй төсөвт батлагдаагүй орон тооны ажлыг хавсран гүйцэтгэж 40 хувийн нэмэгдэл болох 3445960 төгрөгийн цалин авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын 2.2. Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно.

➤ Сумын Засаг даргын албан томилолтоор ажилласан хугацааны томилолтыг бодохдоо ирэх, буцах хоногийг 2 өдрөөр тооцон 3 удаагийн томилолтод 3 хоног илүү тооцон олгосон, мөн аймгийн ИТХ-ын хуралдаанд оролцсон албан томилолтыг аймгийн ИТХ-аас олгосон ч сумын ЗДТГ-ын албан томилолтын зардлаас давхардуулан олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын 2.4-д "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно." Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9.3.Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.

➤ Нэмэлт санхүүжилтийн данс, ЖДҮД сангийн эх үүсвэрээс бүрдүүлсэн өвс тэжээлийн нөөцөөс борлуулсны орлогоос 8,509,554 төгрөгийг дансанд төвлөрүүлээгүй

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Төсвийн тухай хууль 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;"

### **3.2 Албан шаардлага**

➤ Сумын өвс тэжээлийн нөөц нь нэмэлт санхүүжилтийн дансны 25,789,000, ЖДҮД сангийн 53,289,159 нийт 79078159 төгрөгийн эх үүсвэр байна. Үүнээс 47,400,634 төгрөг нь дансны үлдэгдлээр, 16,687,954 мянган төгрөг нь авлагаар, бусад хангамжийн материалын дансанд 2283 боодол буюу 21,999,000 төгрөгийн өвсний нөөцтэй байна. Авлагын үлдэгдэл 8,178,400 төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. 20 дугаар зүйлийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт: Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэргүй захирамжаар зарцуулсан байна.

Энэ нь Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын 4.1-д "Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна."

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулалт хийхдээ Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргаж байх.

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгө

Байгууллагын дотоод хяналт шалгалт хийх журам баталсан ч дотоод хяналт шалгалт зохион байгуулаагүй

Энэ нь ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан журмын 1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3.5-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ." гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулалт хийхдээ Засаг даргын зөвлөлөөс

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс					Зөвлөмж	
						Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	2,269.3	1	2,269.3			1	2,269.3				
Дүн	1	2,269.3	1	2,269.3	-		1	2,269.3	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүрэмт хувцас худалдсан авсан	1	380.0	1	380.0								
Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлээр тайлагнаагүй	1		-	-	1			-		-	-	-
D KIOSK төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	5,000.0			1	5,000.0						
Шатахууныг шууд зардалд бүртгэсэн	1	570.0					1	570.0				
Тайлант хугацааны шатахуун, жолоочийн тооцоо бодоогүй	1	2,606.0					1	2,606.0				
Дүн	5	8,556.0	1	380.0	2	5,000.0	2	3,176.0	-	-	-	-

